



# Элсэлтийн журамд гарсан өөрчлөлтүүд

## Гэр бүлд зориулсан мэдээлэл

### Яагаад нийтийн боловсролыг сонгох вэ?

NSW мужийн нийтийн боловсролын систем нь сурагч бүрт дэлхийн түвшний боловсрол олгож, өнөөгийн хүүхдүүдийг ирээдүйн амжилтад хүрэх, маргаашийн илүү сайхан нийгэм байгуулах чадвартай болгоход чиглэдэг. Шинжлэх ухаан, Технологи, Инженерчлэл, Математик, урлаг, спорт болон бусад салбарыг хамарсан боловсролын цогц, чанартай хөтөлбөр буюу хаана ч байхгүй хосолсон хөтөлбөрийг санал болгосноор манай нийтийг хамарсан, хүртээмжтэй улсын сургуулиуд нь сурагчдыг өөрсдийн потенциалгаа бүрэн ашиглахад нь дэмжлэг үзүүлдэг.

### Элсэлтийн бодлого гэж юу вэ?

Элсэлтийн бодлого нь сургуулиудыг Боловсролын тухай хуулийн (Education Act 1990) дагуу хүлэсэн үүргээ биелүүлэхэд нь тусладаг бөгөөд бүх сурагчдыг харьяа газрынхаа улсын сургуульд суралцах боломжоор хангадаг. Түүнчлэн, энэхүү бодлогын хүрээнд NSW мужийн улсын сургуулиудад элсэлт хэрхэн явагддаг талаар нийт ажилтнууд болон олон нийтэд тодорхой мэдээлэл өгдөг юм.

### Яагаад уг бодлогод өөрчлөлт орж байна вэ?

NSW мужийн Боловсролын Газар нь одоо хэрэгжиж буй элсэлтийн бодлогын талаар бусад боловсролын түнш байгууллагууд, иргэдийн нэгдэл болон сургуулийн удирдлагуудтай уулзаж зөвлөлдсөн билээ. Бид NSW муж дахь улсын сургуулиудад элсэхэд гэр бүлүүдэд тулгардаг бэрхшээлийг шийдвэрлэх шаардлагатай байгаа талаар ихээхэн санал хүсэлт хүлээн авсан. Шинэчилсэн элсэлтийн бодлого нь эдгээр тулгараад байгаа асуудлуудыг шийдэж, улсын сургуулийн тэгш, хүртээмжтэй тогтолцоог бий болгож, үүнийгээ үргэлжлүүлэн хадгалах Боловсролын Газрын үүрэгтэй нийцэж байгаа юм.

### Ямар өөрчлөлтүүд гарсан бэ?

Дараах өөрчлөлтүүд нь 2025 оны 1-р улирлаас эхэлж бүртгүүлсэн бүх сурагчдад хамаарна.

## Түр оршин суугчид

Түр оршин суух визтэй бүх сурагчид оршин суугаа хаягийнхаа дагуу харьяа сургуульдаа элсэх боломжтой болно.

Хөдөө орон нутагт оршин суугаа богино хугацааны ур чадварын визтэй (дэд ангилал 482), өөрөөр хэлбэл Сидней болон Воллонгонгоос бусад нутагт амьдардаг гэр бүлүүдийн хүүхэд элсэлтийн хураамжаас чөлөөлөгдөнө.

## Харьяаллын бус элсэлтийн шинэчилсэн шалгуур

NSW мужийн улсын сургуулиуд нь харьяа газрын тодорхой элсэлтийн бүсүүдтэй байдаг. Эдгээр элсэлтийн бүсүүдийг Боловсролын Газар тогтоодог бөгөөд тухайн сургуулиуд нь тус бүсэд оршин суудаг сурагчдад орон тоо хүрэлцээтэй байхаар зохицуулагддаг. Хэрэв орон тоо байгаа бол, та хүүхдээ тухайн хуваарилагдсан бүсээс гадуур, 'харьяаллын бус элсэлт'-ийн журмын дагуу бүртгүүлэх хүсэлт гаргах боломжтой.

Шинэчлэгдсэн шалгуурт одоо сурч байгаа сурагчдын төрсөн ах, эгч, дүү нарт давуу эрх олгож байгаа бөгөөд шаардлага хангаж буй ерөнхий боловсролын сургуулиудад тусгай дэмжлэгтэй ангид суралцаж байгаа ах, эгч, дүү нарыг элсүүлэх тал дээр нэн тэргүүнд чухалчлан харгалзаж үзэх болно.

Шинэчлэгдсэн шалгуурын дагуу сургуулиуд одоо сургуулийн ажилтнуудын хүүхдүүдийг харьяаллын бус элсэлтийн бүртгэлд хамруулж болно.

## Түгээмэл асуугддаг асуултууд

### Эдгээр өөрчлөлтүүд миний хүүхдэд хамааралтай юу?

NSW мужийн улсын сургуулиудын элсэлтийн өөрчлөлт нь дараах тохиолдолд танд хамаарна:

- таны хүүхэд сургуулийн насны бөгөөд түр оршин суух визтэй, эсвэл
- таны хүүхэд сургуулийн насных ба төрсөн ах, эгч, дүү нар нь NSW мужийн өөр улсын сургуульд сурдаг бөгөөд та хүүхдүүдээ нэг сургуульд сургахыг хүссэн тохиолдолд. Сургууль таны хүүхдийг элсүүлэх эсэх шийдвэр нь сургуулийн хүрэлцээ болон, шалгуур үзүүлэлтээс хамаарна.
- Та, хүүхдийн тань хуваарилагдсан элсэлтийн бүсээс гадуурх NSW мужийн улсын сургуульд ажилладаг тохиолдолд. Сургууль таны хүүхдийг элсүүлэх эсэх шийдвэр нь сургуулийн хүрэлцээ болон, шалгуур үзүүлэлтээс хамаарна.

## Эдгээр өөрчлөлтүүдийг бүх сургууль хэрэгжүүлэх шаардлагатай юу?

Бүх сургуулиуд эдгээр өөрчлөлтүүдийг түр оршин суух визтэй сурагчдад хэрэгжүүлэх шаардлагатай.

Ихэнх сургуулиуд хүчин чадлаасаа хамааран 2025 оны 1-р улиралд элсэн суралцах гэж буй сурагчдад зориулан харьяаллын бус элсэлтэд хамаарах өөрчлөлтийг хэрэгжүүлэх шаардлагатай.

Түр хугацааны оршин суугч визтэй сурагчид болон харьяаллын бус сурагчдад зориулсан эдгээр элсэлтийн бодлогын өөрчлөлтүүд нь тусгай хөтөлбөр, болон нэмэлт дэмжлэгтэй ангийн элсэлтийн шаардлагад нөлөөлөхгүй. Бүрэн сонгон шалгаруулалттай сургуулиуд, тусгай зориулалтын сургуулиуд (schools for specific purposes (SSPs)), зайн сургалттай сургуулиуд, мөн тодорхой элсэлтийн шаардлагатай анги, хөтөлбөртэй сургуулиуд (жишээлбэл, сонгоны ангиуд, мэргэжлийн спорт болон дүрслэх урлагийн ангиуд) одоо мөрдөгдөж буй элсэлтийн журмаа үргэлжлүүлэн мөрдөх болно.

Охид болон хөвгүүдийн сургуулиудын хувьд, тухайн сурагч нь уг сургуулийн сурагчийн хүйс (эр/эм)-нд тавигддаг шаардлагыг хангаж байгаа бол уг өөрчлөлтийг тухайн сургууль хэрэгжүүлэх ёстой. Эдгээр өөрчлөлтүүд хэрхэн хэрэгжүүлж буй талаар холбогдох сургуулиас мэдээлэл авна уу.

### Хэрэв миний хүүхэд одоо суралцаж буй сурагчийн төрсөн ах, эгч, дүү бол харьяаллын бус элсэлтийн хүсэлтийг автоматаар хүлээж авах уу?

Эдгээр өөрчлөлт нь таны хүүхдийн ах, эгч, дүүг харьяаллын бус улсын сургуульд хамт суралцуулж чадна гэсэн баталгаа болж чадахгүй. Сургуулийн захиргаа боломж нь бүрдвэл одоо суралцаж буй сурагчдын ах дүүсийг харьяаллын бус элсэлтэнд элсүүлэх давуу эрхийг өгөх боловч, өргөдөл хүлээн авах эсэх нь сургуулийн хүчин чадлаас шалтгаална. Тухайн сургуультай холбогдож дэлгэрэнгүй мэдээлэл аваарай.

### Үүнээс хойш зөвхөн нэг гэр бүлийн ах дүүсийг харьяаллын бус элсэлтээр авна гэсэн үг үү?

Үгүй, хэрэв хүүхэд тухайн сургуульд орох шаардлагыг хангасан бөгөөд тухайн сургууль хүүхдийг элсүүлэх боломжтой бол та аль ч улсын сургуульд хүүхдээ бүртгүүлэх хүсэлт гаргаж болно. Сургуулиуд шинэчилсэн шалгуурын дагуу (сурагчдын хэрэгцээтэй холбоотой шалгууруудын хамт) одоо суралцаж буй сурагчдын ах, эгч, дүү нар болон, сургуулийн ажилтны хүүхдүүдийг нэн тэргүүнд эрэмбэлэн авч үзэх ёстой.

## Сургуулийн ажилчдын хүүхдүүдийг харьяаллын бус элсэлтийн журмаар шууд авах уу?

Үгүй. Одоо суралцаж буй сурагчдын төрсөн ах, эгч, дүү нарыг эхлээд харьяаллын бус элсэлтэнд авч үзэх ба үүний дараагаар сургуулийн ажилтнуудын хүүхдүүдийн элсэлтийг харгалзан үзэх болно. Хэрэв та сургуулийн ажилтан бол таны хүүхдийг элсүүлэх эсэх нь сургуулийн хүчин чадлаас хамаарна. Харьяаллын бус элсэлтийн шинэчилсэн шалгуур нь таны хүүхдийг харьяа сургуульд элсэх эрхэд нөлөөлөхгүй.

## Түр оршин суух визтэй сурагчийг элсүүлэх

**Манай хүүхэд түр оршин суух визтэй байгаа. Би өмнө нь тэднийг харьяа сургуульд нь элсүүлэх хүсэлт гаргасан боловч татгалзсан. Би хүүхдийнхээ элсэлтийн өргөдлийг дахин гаргаж болох уу?**

Хэрэв таны хүүхэд түр оршин суух визтэй бөгөөд харьяа сургуульд өмнөх өргөдөл нь татгалзсан бол та элсэх өргөдлөө дахин гаргаж болно. Доорх "Хүүхдийнхээ 2025 онд бүртгүүлсэн сургуулийг хэрхэн өөрчлөх вэ?" хэсэгт заасан алхмуудыг дагана уу.

**Манай хүүхэд түр оршин суух визтэй бөгөөд би хүүхдээ 2025 оны элсэлтэнд бүртгүүлчихсэн байгаа. Би хүүхдийнхээ бүртгүүлсэн сургуулийг сольж болох уу?**

Хэрэв таны хүүхэд түр оршин суух визтэй бөгөөд аль хэдийн 2025 оны элсэлтэнд хамрагдсан бол одоо элссэн сургуулиа өөрчлөх хүсэлт гаргах боломжтой. Доорх "Би хүүхдийнхээ 2025 онд бүртгүүлсэн сургуулийг хэрхэн өөрчлөх вэ?" хэсэгт заасан алхмуудыг дагана уу.

**Хүүхдийнхээ 2025 оны хичээлийн жилд бүртгүүлсэн сургуулийг нь хэрхэн өөрчлөх вэ?**

Түр оршин суух визтэй сурагчдын эцэг эх, асран хамгаалагчид харьяа сургуулийн элсэлтээ өөрчлөхийн тулд дараах алхмуудыг хийх шаардлагатай:

1. Хүүхдийнхээ сургуулийг солих хүсэлт гаргахын тулд 1300 300 229 (сонголт 1) эсвэл [tempvisa@det.nsw.edu.au](mailto:tempvisa@det.nsw.edu.au) цахим шуудангаар Түр Оршин Суугч Хөтөлбөрийн багтай холбогдоно уу. Таны хүүхдийн сургууль солих хүсэлт амжилттай шийдвэрлэгдсэний дараа Түр Оршин Суугч Хөтөлбөрийн баг тантай холбогдох болно.
2. Хүүхдээ бүртгүүлэхийн тулд харьяа сургуультайгаа холбогдоно уу. Сургууль танд элсэлтэнд шаардлагатай цаасан өргөдлийн маягтыг өгөх болно. Өөрийн харьяа сургуулийн холбоо барих хаягийг [education.nsw.gov.au/find-a-public-school](http://education.nsw.gov.au/find-a-public-school) хаягаас авна уу.

**Хүүхэд маань 482-с өөр ангиллын түр оршин суух визтэй. Би элсэлтийн хураамж төлөх шаардлагатай юу?**

Улсын сургуульд суралцах түр оршин суугчийн өргөдлийн хураамж болон сургалтын төлбөрийг тухайн оюутны эзэмшиж буй визний дэд ангиллаар тооцдог. Таны визний дэд ангилалд хамаарах хураамжийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг DE International вэбсайтаас авна уу: [deinternational.nsw.edu.au/study-options/study-programs/temporary-residents](http://deinternational.nsw.edu.au/study-options/study-programs/temporary-residents). Хэрэв та төлбөрөөс чөлөөлөгдөх эсэхээ мэдэхгүй байгаа бол [tempvisa@det.nsw.edu.au](mailto:tempvisa@det.nsw.edu.au) хаягаар Түр Оршин Суугчдын Хөтөлбөрийн багтай холбогдож болно.

## Харьяаллын бус төрсөн ах, эгч, дүү нартай холбоотой элсэлт

**Би хүүхдээ ах, эгч, дүүгийнх нь сурдаг сургуульд оруулах хүсэлт гаргасан боловч татгалзсан. Би хүүхдийнхээ элсэлтийн өргөдлийг дахин гаргаж болох уу?**

Хэрэв та хүүхдээ ах, эгч дүүгийнх нь харьяаллын бус сургуульд элсүүлэх хүсэлт гаргаад татгалзсан хариу авсан бол доорх "2025 онд хүүхдийнхээ бүртгүүлсэн сургуулийг хэрхэн өөрчлөх вэ?" хэсэгт дурдсан алхмуудыг дагаж хүсэлтээ дахин гаргана уу.

**Би хүүхдээ 2025 оны элсэлтэнд хамруулсан боловч ах, эгч, дүү нь харьяаллын бус өөр сургуульд орсон. Би хүүхдүүдийнхээ бүртгүүлсэн сургуулийг өөрчлөх хүсэлт гаргаж болох уу?**

Та хүүхдийнхээ 2025 онд элсүүлсэн сургуулийг ах, эгч, дүүгийнх нь сурч байгаа харьяаллын бус сургууль руу шилжүүлэхийг хүсвэл доорх "Би 2025 онд хүүхдийнхээ бүртгүүлсэн сургуулийг хэрхэн өөрчлөх вэ?" хэсэгт заасан алхмуудыг дагана уу.

**Би хүүхдийнхээ 2025 онд бүртгүүлсэн сургуулийг хэрхэн өөрчлөх вэ?**

Хүүхдээ ах, эгч дүүгийн хамт нэг сургуульд оруулах хүсэлтэй эцэг эх, асран хамгаалагчид элсэлтээ өөрчлөхийн тулд дараах алхмуудыг хийх шаардлагатай.

## Онлайн элсэлтийн өргөдөл

1. Бүртгүүлэхийг хүсч буй сургуулийн вэб сайт руу орж, цэсийн сонголтуудаас элсэлт дээр дарна уу.
2. Элсэлтийн вэб хуудасны "Хэрхэн бүртгүүлэх вэ" гэсэн гарчигтай цахим элсэлтийн өргөдлийн холбоос дээр дарна уу.
3. Элсэх хүсэлтээ гаргасны дараа сургууль таны хүүхдийг элсүүлэх санал тавьж болох бөгөөд энэ тохиолдолд та 14 хоногийн дотор хариу өгөх ёстой.
4. Хэрэв таны хүсэлт зөвшөөрөгдсөн бол 2025 онд суралцахаар өмнө нь бүртгүүлсэн сургуультай эргэн холбогдож бүртгэлээ цуцлаарай.

## Цаасан өргөдөл

1. Хүүхдийнхээ ах, эгч, дүүгийн суралцаж буй сургуультай холбогдож, анги дүүргэлтийн талаар олж мэдээрэй.
2. Сургууль таны хүүхдийг хүлээн авах боломжтой бол сургуулиас өгөх шинэ цаасан анкет бөглөнө үү.
3. Элсэх хүсэлтээ гаргасны дараа сургууль таны хүүхдийг элсүүлэх санал тавьж болох бөгөөд энэ тохиолдолд та 14 хоногийн дотор хариу өгөх ёстой.
4. Хэрэв таны хүсэлт зөвшөөрөгдсөн бол 2025 онд суралцахаар өмнө нь бүртгүүлсэн сургуультай эргэн холбогдож бүртгэлээ цуцлаарай.

### Би 2025 онд 6-р ангиас 7-р анги руу шилжих талаар илэрхийлсэн сонирхлын мэдүүлгээ (Expression of Interest (EOI)) өгсөн. Хүүхдээ хаана бүртгүүлсэнээ өөрчилж болох уу?

6-р ангиас 7-р анги руу шилжих EOI хугацаа дууссан тул эцэг эх, асран хамгаалагчид 2025 оны сургууль сонголтын жагсаалтад өөрчлөлт оруулах боломжгүй болсон.

2025 онд хүүхдээ бүртгүүлсэн сургуулийг ах, эгч, дүүгийнх нь сурдаг харьяаллын бус сургууль руу солихыг хүсвэл дараах алхмуудыг дагана уу.

## Онлайн элсэлтийн өргөдөл

1. Бүртгүүлэхийг хүсч буй сургуулийн вэб сайт руу орж, цэсийн сонголтуудаас элсэлт дээр дарна уу.
2. Элсэлтийн вэб хуудасны "Хэрхэн бүртгүүлэх вэ" гэсэн гарчигтай цахим элсэлтийн өргөдлийн холбоос дээр дарна уу.
3. Элсэх хүсэлтээ гаргасны дараа сургууль таны хүүхдийг элсүүлэх санал тавьж болох бөгөөд энэ тохиолдолд та 14 хоногийн дотор хариу өгөх ёстой.
4. Хэрэв таны хүсэлт зөвшөөрөгдсөн бол 2025 онд суралцахаар өмнө нь бүртгүүлсэн сургуультай эргэн холбогдож бүртгэлээ цуцлаарай.

## Цаасан өргөдөл

1. Хүүхдийнхээ ах, эгч, дүүгийн суралцаж буй сургуультай холбогдож, анги дүүргэлтийн талаар олж мэдээрэй. Сургуультай холбоо барих мэдээллийг дараах хаягаар авна уу: [education.nsw.gov.au/find-a-public-school](http://education.nsw.gov.au/find-a-public-school).
2. Сургууль таны хүүхдийг хүлээн авах боломжтой бол сургуулиас өгөх шинэ цаасан анкет бөглөнө үү.
3. Элсэх хүсэлтээ гаргасны дараа сургууль таны хүүхдийг элсүүлэх санал тавьж болох бөгөөд энэ тохиолдолд та 14 хоногийн дотор хариу өгөх ёстой.
4. Хэрэв таны хүсэлт зөвшөөрөгдсөн бөгөөд мөн EOI саналыг та хүлээн зөвшөөрсөн бол өмнө нь бүртгүүлсэн сургуультай эргэн холбогдож бүртгэлээ цуцлаарай.

## Сургуулийн ажилчдын хүүхдүүдийг харьяаллын бус элсэлтэнд хамруулах

**Би хүүхдээ өөрийнхөө ажилладаг сургуульд элсүүлэх хүсэлт гаргасан боловч татгалзсан. Би хүүхдийнхээ элсэлтийн өргөдлийг дахин гаргаж болох уу?**

Хэрэв та хүүхдээ өөрийн ажилладаг сургуульдаа бүртгүүлэх хүсэлт гаргасан боловч татгалзсан хариу авсан бол дахин бүртгүүлэх боломжтой. Үүний тулд, "Би 2025 онд хүүхдийнхээ бүртгүүлсэн сургуулийг хэрхэн өөрчлөх вэ?" хэсэгт заасан алхмуудыг дагана уу.

### Дэлгэрэнгүй мэдээллийг хаанаас олж болох вэ?

Танд элсэлттэй холбоотой асуулт байвад өөрийн сонгосон сургуультай холбогдоно уу. Сургуультай холбоо барих мэдээллийг дараах хаягаас авна уу: [education.nsw.gov.au/find-a-public-school](http://education.nsw.gov.au/find-a-public-school)

NSW мужийн улсын сургуульд хэрхэн элсэх талаар дэлгэрэнгүй мэдээллийг: [education.nsw.gov.au/enrolment](http://education.nsw.gov.au/enrolment)

NSW мужийн улсын сургуульд түр оршин суугчаар хэрхэн элсэх талаар дэлгэрэнгүй мэдээллийг: <https://www.deinternational.nsw.edu.au/>

Элсэлтийн талаар ерөнхий асуулт байвал Боловсролын Газрын төв оффис руу залгана уу: 1300 679 332

### Утсан орчуулгын үйлчилгээ

Хэрвээ танд сургуультай холбогдох орчуулагчийн тусламж хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээ болох 13 14 50 дугаарт залгаж өөрийн эх хэл дээр орчуулагч авъя гэж хэлээрэй. Операторт та утасны дугаараа үлдээснээр оператор таньд туслах орчуулагчийг олж тантай эргэн холбогдох болно. Энэхүү үйлчилгээ нь үнэ төлбөргүй.